

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмана сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/036/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/036/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.16 № 64

танай _____ -ны № _____ -т

ЧАНДМАНЬ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ч.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмана сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- "Байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдад нэмэгдэл цалин олгох тухай" байгууллагын даргын 2025 оны Б/06 дугаар тушаалаар 2 дугаар сард олгосон 14,595.9 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг 3 дугаар сард давхардуулан олгосон.
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 56 дугаар тогтоолд заасан 151,273.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасаагүй шийдвэрийг хэрэгжүүлээгүй.
- Дансанд бүртгэлтэй 90,099.3 мянган төгрөгийн эм, боох материалыг тооллогын комисс тоолоогүй.

822505000185

- Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 119 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 56 дугаар тогтоол, 2025 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1, Чандмана сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны Б/06 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3-т "хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд 1126 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн ба өмнөх оны авлага барагдуулж 100,310.9 мянган төгрөгийг санхүүжилт олгосон байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 13,254.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар ирсэн 49,499.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

Аудитын гол асуудал

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 1,112,271.9 мянган төгрөг нэхэмжилснээс 1,068,352.6 мянган төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж, 43,919.3 мянган төгрөг авлагаар тайлагнажээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 3 зорилтын хүрээнд 80 арга хэмжээ хэрэгжүүлэхээр сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан гүйцэтгэлээр 94.9 хувиар дүгнүүлжээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулан ажиллаж, гэрээний биелэлт 87.5 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан СТ-1 (төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	49,145.48	26,688,450.11
Банканд байгаа бэлэн мөнгө/ төгрөгөөр/	49,145.48	26,688,450.11
Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгө	49,145.48	26,688,450.11
АВЛАГА	100,310,949.78	47,969,182.11
Төлбөртэй үйлчилгээний авлага	100,310,949.78	43,919,325.64
Ажиллагсадтай холбогдсон авлага	-	4,049,856.47
БАРАА МАТЕРИАЛ	182,850,607.08	221,331,809.59
Түүхий эд материал	72,257,013.57	97,215,816.08
Тусгай зориулалттай материал	7,116,545.50	7,116,545.50
Эм боох материал	65,140,468.07	90,099,270.58
Хангамжийн материал	110,593,593.51	124,115,993.51
Бичиг хэргийн материал	3,349,450.00	3,945,050.00
Аж ахуйн материал	104,915,143.51	113,253,943.51
Сэлбэг хэрэгсэл	885,000.00	885,000.00
Түлш, шатах тослох материал	-	5,400,000.00
Хүнсний материал	1,444,000.00	632,000.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	283,210,702.34	295,989,441.81
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,023,026,844.41	968,567,867.37
Биет хөрөнгө	1,017,492,844.41	963,033,867.37
Барилга, байгууламж, орон сууц	867,792,959.03	862,792,959.03
Хуримтлагдсан элэгдэл	(83,273,031.78)	(135,546,114.94)
Авто-тээврийн хэрэгсэл	110,088,434.00	126,352,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(39,110,834.00)	(19,805,433.35)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	266,993,282.68	174,577,795.68
Хуримтлагдсан элэгдэл	(162,595,172.74)	(91,621,438.59)
Тавилга, аж ахуйн эд хогшил	49,058,655.00	41,690,129.80
Хуримтлагдсан элэгдэл	(24,591,804.53)	(25,817,653.05)
Бусад үндсэн хөрөнгө	38,427,128.35	40,427,128.35
Хуримтлагдсан элэгдэл	(5,445,736.60)	(10,164,470.56)
ном	148,965.00	148,965.00
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	5,534,000.00	5,534,000.00
Хуримтлагдсан элэгдэл	550,000.00	550,000.00
Бусад биет бус хөрөнгө	(550,000.00)	(550,000.00)
Хуримтлагдсан элэгдэл	5,534,000.00	5,534,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,023,026,844.41	968,567,867.37
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,306,237,546.75</u>	<u>1,264,557,309.18</u>
Ажилчидтай холбогдсон өглөг	27,147,901.30	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	17,709,350.00	-
Байгууллагад төлөх	88,006,315.08	20,185,816.24
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	132,863,566.38	20,185,816.24
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	132,863,566.38	20,185,816.24
Засгийн газрын хувь оролцоо	307,424,380.50	307,424,380.50

Дахин үнэлгээний нэмэгдэл	2,293,795.01	2,293,795.01
Хуримтлагдсан үр дүн	863,655,804.86	934,653,317.43
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,173,373,980.37	1,244,371,492.94
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,306,237,546.75</u>	<u>1,264,557,309.18</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан СТ-2 (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ	ТАЙЛАНТ ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,397,362,300.96	1,250,637,940.60
Орон нутгийн төсвөөс	462,669,800.00	138,365,500.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас	934,692,500.96	1,112,272,440.60
Бараа, үйлчилгээний орлого	118,317,512.05	67,509,445.04
Хандивын тусламжийн орлого Үндсэн хөрөнгө	66,326,172.84	49,499,100.00
Хандивын тусламжийн орлого Бараа материал	51,991,339.21	17,689,045.04
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	321,300.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,515,679,813.01	1,318,147,385.64
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
<u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>	722,906,456.93	904,909,696.03
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	643,096,356.93	806,415,896.03
Үндсэн цалин	336,609,943.12	357,970,855.73
Нэмэгдэл	216,833,422.45	359,794,757.73
Унаа хоолны хөнгөлөлт	17,659,100.57	22,506,264.70
Урамшуулал	71,993,890.79	66,144,017.87
Нийгмийн хамгааллын шимтгэл	79,810,100.00	98,493,800.00
Тэтгэврийн даатгал	53,223,300.00	66,517,800.00
Тэтгэмжийн даатгал	6,261,600.00	8,062,400.00
ҮОМШӨ-ний даатгал	3,130,800.00	4,032,300.00
Ажилгүйдлийн даатгал	3,130,800.00	3,756,600.00
Эрүүл мэндийн даатгал	14,063,600.00	16,124,700.00
<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u>	282,878,530.37	335,001,593.76
Тогтмол зардал	68,237,476.41	75,172,566.72
Гэрэл цахилгааны зардал	6,608,590.41	6,647,000.00
Түлш, халаалтын зардал	61,628,886.00	68,525,566.72
Нормативт зардал	97,277,198.18	84,480,413.00
Эм	90,338,548.18	71,248,663.00
Хоол	6,938,650.00	8,091,750.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	-	5,140,000.00
Хангамж бараа үйлчилгээний зардал	35,343,996.00	39,692,177.00
Бичиг хэргийн материал	952,800.00	2,394,700.00
Тээвэр, шатахууны зардал	31,106,550.00	34,072,480.00
Шуудан холбооны зардал	3,196,646.00	2,830,997.00
Хог хаягдал зайлуулах зардал	-	100,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл	88,000.00	294,000.00
Эд хогшил урсгал засварын зардал	-	275,000.00
Багаж техник, хэрэгсэл	-	275,000.00

Томилолт зочны зардал	13,120,000.00	5,240,000.00
Дотоод томилолтын зардал	13,120,000.00	5,240,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,049,800.00	9,429,360.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,445,000.00	2,061,750.00
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	604,800.00	1,353,600.00
Даатгалын үйлчилгээ	-	400,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	-	4,398,000.00
Маягт хэвлүүлэх зардал	-	1,216,010.00
Бараа үйлчилгээний бусад зардал	66,850,059.78	120,712,077.04
Бусад зардал	736,400.00	1,500,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,113,659.78	119,212,077.04
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,049,121.59	7,238,583.28
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,049,121.59	6,108,583.28
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,049,121.59	6,108,583.28
Бусад урсгал шилжүүлэг	-	1,130,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,130,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,007,834,108.89	1,247,149,873.07
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	507,845,704.12	70,997,512.57
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	507,845,704.12	70,997,512.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан **СТ-3** (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	1,299,276,095.18	1,307,029,564.74
Орон нутгийн төсвөөс	462,669,800.00	138,365,500.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас	836,606,295.18	1,168,664,064.74
Бараа, үйлчилгээний орлого	-	321,300.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	321,300.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,299,276,095.18	1,307,350,864.74
Ажиллагчидтай холбогдсон зардал	696,225,998.29	936,107,453.80
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	616,415,898.29	831,738,653.80
Үндсэн цалин	309,929,484.48	362,020,712.20
Нэмэгдлүүд	216,833,422.45	381,067,659.03
Унаа хоолны хөнгөлөлт	17,659,100.57	22,506,264.70
Урамшуулал	71,993,890.79	66,144,017.87
Нийгмийн хамгааллын шимтгэл	79,810,100.00	104,368,800.00
Тэтгэврийн даатгал	53,223,300.00	70,238,200.00
Тэтгэмжийн даатгал	6,261,600.00	8,532,400.00
ҮОМШӨ-ний даатгал	3,130,800.00	4,267,300.00
Ажилгүйдлийн даатгал	3,130,800.00	4,266,200.00
Эрүүл мэндийн даатгал	14,063,600.00	17,064,700.00
Бараа, үйлчилгээний урсгал зардал	181,555,940.69	324,111,523.03

Чандмана сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тогтмол зардал	50,528,126.41	92,881,916.72
Гэрэл цахилгааны зардал	6,608,590.41	6,647,000.00
Түлш, халаалтын зардал	43,919,536.00	86,234,916.72
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	78,653,318.28	114,751,669.31
Эм	61,119,018.28	100,577,419.31
Хоол	7,537,500.00	8,206,250.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,996,800.00	5,968,000.00
Хангамж бараа үйлчилгээний зардал	38,359,796.00	51,688,777.00
Бичиг хэрэг	2,822,900.00	3,185,300.00
Тээвэр, шатахуун	31,106,550.00	39,472,480.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,196,646.00	2,830,997.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	100,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,233,700.00	6,100,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,057,700.00	43,159,800.00
Багаж, техник, хэрэгсэл	850,000.00	275,000.00
Урсгал засвар	1,207,700.00	42,884,800.00
Томилолт, зочны зардал	7,660,000.00	10,700,000.00
Дотоод албан томилолт	7,660,000.00	10,700,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,049,800.00	9,429,360.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,445,000.00	2,061,750.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	1,353,600.00
Тээврийн хэрэгслийн татвар	-	400,000.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	4,398,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	1,216,010.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,247,200.00	1,500,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,247,200.00	1,500,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,049,121.59	7,238,583.28
Бусад урсгал шилжүүлэг	-	1,130,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,130,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,049,121.59	6,108,583.28
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,049,121.59	6,108,583.28
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	879,831,060.57	1,267,457,560.11
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	419,445,034.61	39,893,304.63
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	423,579,552.00	13,254,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	423,579,552.00	13,254,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(423,579,552.00)	(13,254,000.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	(4,134,517.39)	26,639,304.63
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,183,662.87	49,145.48
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,145.48	26,688,450.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТА - 4 (төгрөг)

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	307,424,380.50	2,293,795.01	355,810,100.74	665,528,276.25
Залруулсан үлдэгдэл	307,424,380.50	2,293,795.01	355,810,100.74	665,528,276.25
Тайлант үеийн үр дүн			507,845,704.12	507,845,704.12
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	307,424,380.50	2,293,795.01	863,655,804.86	1,173,373,980.37
Залруулсан үлдэгдэл	307,424,380.50	2,293,795.01	863,655,804.86	1,173,373,980.37
Тайлант үеийн үр дүн			70,997,512.57	70,997,512.570
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	307,424,380.50	2,293,795.01	934,653,317.43	1,244,371,492.94

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан СТ-4-1 (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Татаас, санхүүжилтийн орлого	1,160,234,500.00	1,168,664,064.74	(8,429,564.74)	100.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас	1,160,234,500.00	1,168,664,064.74	(8,429,564.74)	100.7
Бараа, үйлчилгээний орлого	49,100.00	321,300.00	(272,200.00)	654.4
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	321,300.00	(321,300.00)	-
Урьд оны үлдэгдлээс	49,100.00	-	49,100.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,160,283,600.00	1,168,985,364.74	(8,701,764.74)	100.7
Ажиллагчидтай холбогдсон зардал	954,218,200.00	936,107,453.80	18,110,746.20	98.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	849,849,400.00	831,738,653.80	18,110,746.20	97.9
Үндсэн цалин	371,764,700.00	362,020,712.20	9,743,987.80	97.4
Нэмэгдэл	384,131,900.00	381,067,659.03	3,064,240.97	99.2
Унаа хоолны хөнгөлөлт	33,656,500.00	22,506,264.70	11,150,235.30	66.9
Урамшуулал	60,296,300.00	66,144,017.87	(5,847,717.87)	109.7
Нийгмийн хамгааллын шимтгэл	104,368,800.00	104,368,800.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	70,238,200.00	70,238,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	8,532,400.00	8,532,400.00	-	100.0
Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	4,267,300.00	4,267,300.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	4,266,200.00	4,266,200.00	-	100.0

Чандмана сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Эрүүл мэндийн даатгал	17,064,700.00	17,064,700.00	-	100.0
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	196,204,700.00	191,854,606.31	4,350,093.69	97.8
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	115,616,400.00	114,751,669.31	864,730.69	99.3
Эм, боох материал	97,500,000.00	100,577,419.31	(3,077,419.31)	103.2
Хоол, хүнс	11,616,400.00	8,206,250.00	3,410,150.00	70.6
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	6,500,000.00	5,968,000.00	532,000.00	91.8
Бусад бараа үйлчилгээний зардал	52,552,200.00	51,688,777.00	863,423.00	98.4
Бичиг хэргийн материал	4,500,000.00	3,185,300.00	1,314,700.00	70.8
Тээвэр, шатахууны зардал	39,536,000.00	39,472,480.00	63,520.00	99.8
Шуудан холбооны зардал	2,263,700.00	2,830,997.00	(567,297.00)	125.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	152,500.00	100,000.00	52,500.00	65.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,100,000.00	6,100,000.00	-	100.0
Жижиг эд хогшил худалдан авах зардал	4,000,000.00	3,784,800.00	215,200.00	94.6
Багаж хэрэгсэл	-	275,000.00	(275,000.00)	-
Урсгал засварын зардал	4,000,000.00	3,509,800.00	490,200.00	87.7
Томилолт зочны зардал	10,700,000.00	10,700,000.00	-	100.0
Дотоод томилолтын зардал	10,700,000.00	10,700,000.00	-	100.0
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,836,100.00	9,429,360.00	2,406,740.00	79.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,223,600.00	2,061,750.00	161,850.00	92.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,300,000.00	1,353,600.00	946,400.00	58.9
Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,450,000.00	4,398,000.00	1,052,000.00	80.7
Маягт хэвлүүлэх зардал	1,462,500.00	1,216,010.00	246,490.00	83.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
Бусад зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
<u>Урсгал шилжүүлэг</u>	9,860,700.00	14,384,000.00	(4,523,300.00)	145.9
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,130,000.00	870,000.00	56.5
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	7,860,700.00	13,254,000.00	(5,393,300.00)	168.6
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,160,283,600.00	1,142,346,060.11	17,937,539.89	98.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49,145.48	49,145.48	-	100.0

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	26,639,304.63	-	-
---	---	---------------	---	---

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсвийн/ СТ-4-2 / (төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	138,365,500.00	132,256,916.72	6,108,583.28	95.6
Орон нутгийн төсвөөс	138,365,500.00	132,256,916.72	6,108,583.28	95.6
Гэрэл цахилгааны зардал	6,647,000.00	6,647,000.00	-	100.0
Түлш, халаалтын зардал	92,343,500.00	86,234,916.71	6,108,583.29	93.4
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	138,365,500.00	132,256,916.71	6,108,583.29	95.6

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 404,120.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй тайлантай холбоотой:** Гэрэл цахилгааны зардлын 7,168.3 мянган төгрөг, түлш халаалтын зардлын 59,503.7 мянган төгрөгийг тооцоо үүсгээгүй шууд зардал болгосон, багаж хэрэгслийн зардлаас 3,938.0 мянган төгрөгийн компьютер, эм боох материалаас 3199.0 мянган төгрөгийн компьютер худалдан авсан, орлогыг бараа материалын тусгай зориулалттай орлого авсан, тайлант онд 4,028.0 мянган төгрөгийн компьютер, принтер худалдан авч бусад хөрөнгөнд бүртгэж орлого авсан, цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг 4,049.8 мянган төгрөг илүү төлсөн, авлагаар тайлагнаагүй алдааг залруулсан.
- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Аймгийн ИТХ-ын 2025 оны 56 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн 151,273.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй, Шилэн дансны цахим системд 177,360.3 мянган төгрөгийн 12 мэдээллийг нөхөн байршуулсан.

Залруулагдаагүй 104,695.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн. Аудитаар илэрсэн 104,695.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж, 1 албан шаардлага, 1 төлбөрийн акт тогтоосон.

3.2 Төлбөрийн акт

1. "Байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдад нэмэгдэл цалин олгох тухай" байгууллагын даргын 2025 оны Б/06 дугаар тушаалаар 2 дугаар сард олгосон 14,595.9 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг 3 дугаар сард давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Чандмана сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны Б/06 дугаар тушаалтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Давхар олгосон нэмэгдэл цалин 14,595.9 мянган төгрөгийг суутган тооцож төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага:

1. Дансанд бүртгэлтэй 90,099.3 мянган төгрөгийн эм, боох материалыг тооллогын комисс тоолоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 20 дугаар зүйлийн 20.1.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эм боох материалын тооллогыг хууль тогтоомжид заасны дагуу хийж баримтжуулан баталгаажуулах ажлыг зохион байгуулах албан шаардлага өгсөн

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Хандив тусламжаар ирсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 119 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ы 2 дугаар зүйлийн 2.1.3-т "хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл", Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2025 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т "Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, орон нутгийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах, дахин үнэлгээ хийх зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт, зөвлөмж гаргуулж ажиллах.

Хоёр. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 56 дугаар тогтоолоор 151,273.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах шийдвэр гарсан боловч тайлант онд акталж, устгал хийх ажлыг зохион байгуулаагүй нь Аймгийн ИТХ-ын 2025 оны 56 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Данснаас хассан хөрөнгийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу комисс томилон устгал хийж баримтжуулах ажлыг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийг биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Чандмана сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тайлант мянган компьютер, худалдан авч хөрөнгөнд бүртгэж орлого авсан.	Төгрөгийн принтер бусад	4,028.0	1	4,028.0	1	4,028.0	-	4,028.0	1	4,028.0	-	-	-
Цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг 4,049.8 мянган төгрөг илүү төлсөн, авлагаар тайлагнаагүй.	4,049.8	1	4,049.8	-	4,049.8	-	4,049.8	1	4,049.8	-	-	-	-
Дүн		6	404,120.6	3	332,683.6	3	71,437.0	6	404,120.6	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан санхүүгийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Чандмана сумын эрүүл мэндийн төв	Байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын Б/06 дугаар "Байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдад нэмэгдэл цалин олгох тухай" тушаалаар 2 дугаар сард олгосон 14,595.8 мянган төгрөгийн цалинг 3 дугаар сард давхардуулан олгосон.	1	14,595.8	1	14,595.8	-	-	-	-
	Тооллогын комисс нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй 90,099.3 мянган төгрөгийн эм боох материалыг тоолоогүй байна.	1	90,099.3	-	-	1	90,099.3	-	-
	Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 119 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан	1	-	-	-	-	-	1	-

Чандмана сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 56 дугаар тогтоолоор 151,273.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах шийдвэр гарсан боловч тайлант онд акталж, устгал хийх ажлыг зохион байгуулаагүй байна.	1	-	-	-	-	1	-	-
		4	104,695.1	1	14,595.8	1	90,099.3	2	-
	Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийсэн хэлбэр	Өрчлөлгүй	Хязгарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1				1			
	НИЙТ	1	1				1			

Бүтэцтэй байгаа үйлчилгээний үйлдвэр